өнөө

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН УДИРДАХ АЖИЛТНЫ ЗӨВЛӨГӨӨН 2024 ОРХОН АЙМАГ

# Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний өнөөгийн байдал цаашдын чиг хандлага

НЭМТ-ийн ахлах мэргэжилтэн А.Ганчимэг

# БОДЛОГЫН БИЧИГ БАРИМТ




АЛСЫН ХАРАА 2050

ХҮНИЙ ХӨГЖИЛ

## ЭРҮҮЛ МЭНД

**ЗОРИЛТ 2.2.** Эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэнийг төлөвшүүлэн эрүүл мэндийн чанар, хүртээмж, үр дүнтэй тогтолцоог хөгжүүлнэ.

ХӨГЖЛИЙН ҮЕ ШАТ · ХҮРЭХ ҮР ДҮН

| I ҮЕ ШАТ \| 2021-2030 | II ҮЕ ШАТ \| 2031-2040 | III ҮЕ ШАТ \| 2041-2050 |
|---|---|---|
| Эрүүл мэндийн чанар, хүртээмжтэй тогтолцооны шинэчлэлийн үе | Амьдралын зөв дадал, хэвшилтэй иргэнийг төлөвшүүлэх үе | Эрүүл амьдралын хэв маягийг дэмжих үе |

АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА

## ЭРҮҮЛ, ИДЭВХТЭЙ АМЬДРАЛЫН ХЭВ МАЯГ

**ЗОРИЛТ 3.5** Идэвхтэй амьдралын хэвшилтэй иргэн, гэр бүлийг дэмжиж, биеийн тамир, спортын ээлтэй орчныг бүрдүүлнэ.

ХӨГЖЛИЙН ҮЕ ШАТ · ХҮРЭХ ҮР ДҮН

| I ҮЕ ШАТ \| 2021-2030 | II ҮЕ ШАТ \| 2031-2040 | III ҮЕ ШАТ \| 2041-2050 |
|---|---|---|
| Биеийн тамир, спортын чанар, хүртээмжтэй, үр дүнтэй тогтолцоог бүрдүүлэх үе | Идэвхтэй амьдралын хэвшилтэй иргэнийг төлөвшүүлэх биеийн тамир, спортын чанар, үр дүнтэй тогтолцоог хөгжүүлэх үе | Биеийн тамир, спортыг идэвхтэй амьдралын хэвшилтэй иргэн, гэр бүл төлөвших үе |




**Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хууль**
**7 бүлэг, 22 зүйлтэй**

# НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН НЭН ШААРДЛАГАТАЙ 10 ГОЛ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

1. Хүн амын сайн сайхан байдлыг судлах, тандах

2. Эрүүл мэндийн онцгой байдлын үеийн шуурхай хариу арга хэмжээг авах, тогтмол хянах

3. Эрүүл мэндэд нөлөөлж буй хүчин зүйлсийн талаар иргэдэд мэдээлэл өгөх

4. Хүн амын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эрүүл мэндээ хамгаалахад татан оролцуулах, идэвхжүүлэх

5. Эрүүл мэндэд нөлөөлөх бодлого төлөвлөгөө, хуулийг бий болгож дэмжин хэрэгжүүлэх



6. Орчны, хөдөлмөрийн, хүнсний аюулгүй байдлыг хангах, эрүүл мэндийг хамгаалах бусад арга хэмжээг хэрэгжүүлэх

7. Тусламж үйлчилгээг тэгш хүртэх боломжийг олгох, үр дүнтэй тогтолцоог бий болгох

8. Нийгмийн эрүүл мэндийн чадварлаг боловсон хүчний нөөцийг хүртээмжтэй бүрдүүлэх

9. Тандалт судалгааг өргөжүүлж нотолгоонд суурилсан бодлого боловсруулах, хэрэгжүүлэх

10. НЭМ-ийн тусламж үйлчилгээг үзүүлэх бүтэц, санхүүжилтийн тогтвортой байдлыг бий болгох, хадгалах

# Нийгмийн эрүүл мэндийн төвийн хүний нөөц



**Орхон аймгийн Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн төв**

Аймгийн Засаг даргын
2017 оны 4-р сарын 06-ны А/184

- Халдварт - 3
- Халдварт бус - 1
- Орчны эрүүл мэнд - 1
- Хоол тэжээл, хүнсний аюулгүй байдал, амны хөндийн эрүүл ахуйн тусламж - 1
- Сэтгэл зүйн тусламж үйлчилгээ - 1
- Осол гэмтэл, нийтийн биеийн тамир чийрэгжүүлэлт - 1
- Мэдээлэл сургалт, сурталчилгаа - 1
- Зураглаач, эвлүүлэгч - 1

**"Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай" хууль**

2024 оны 01-р сарын 12

- Халдварт халдварт бус хяналт
- Орчны эрүүл мэнд
- Хөдөлмөрийн эрүүл мэнд
- Нийгэм сэтгэл зүйн эрүүл мэнд
- Нөхөн үржихүйн эрүүл мэнд
- Хүнсний аюулгүй байдал шим судлал
- Нийгмийн ноцтой байдлын хариу арга хэмжээ
- Нийгмийн эрүүл мэндийн лаборатори

# Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжиж буй арга хэмжээ




1. ЖЕНДЕРТ СУУРИЛСАН БОЛОН ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ 2024-2027ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ
2. ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАР ДАХЬ ХҮҮХДИЙН ЭРХ, ХАМГААЛЛЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ 2024-2026 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ
3. СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНД АРГА ХЭМЖЭЭНИЙ 2024-2027 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

# Арга хэмжээний төлөвлөгөөний 2023 оны хэрэгжилт

- Хавдрын эсрэг арга хэмжээ 80.2%
- Харшлаас сэрийлэх эсрэг арга хэмжээ 93.5%
- Эрүүл чийрэг эр хүн арга хэмжээ 87.5%
- Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд 88.1%
- Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээ 90.7%
- Орчны эрүүл мэндийн хөтөлбөр 88.5%
- Эрүүл идэвхтэй амьдарал арга хэмжээ 84.8%

# Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний санхүүжилт

| 2022 он | | 2023 он |
|---|---|---|
| 83.8% | Хэрэгжилт | 87.7% |

| 2022 он | | 2023 он |
|---|---|---|
| 54 сая | Орон нутаг | 181 сая |
| 21 сая | Улсын төсөв | 63 сая |
| 10.1 сая | Олон Улсын төсөл хөтөлбөр | 9 сая |

# Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН УДИРДАХ АЖИЛТНЫ ЗӨВЛӨГӨӨН 2024 ОРХОН АЙМАГ



## Орхон аймаг 48,554 иргэн хамрагдаж 45.7 хувь

**АЙМГУУДЫН ХҮН АМЫН ХАМРАГДАЛТ**




**НАСНЫ БАГЦЫН ХАМРАГДАЛТ ӨВЧЛӨЛИЙН СЭЖИГТЭЙ ТОХИОЛДЛЫН ТОО**




**БҮРТГЭГДСЭН ӨВЧЛӨЛИЙН ТЭРГҮҮЛЭХ ШАЛТГААН**

Хоол боловсруулах тогтолцооны өвчин
**9,717**

Зүрх судасны тогтолцооны өвчин
**3,395**

Дотоод шүүрэл, бодисын солилцооны өвчин
**3,357**

Шээс, бэлгийн тогтолцооны өвчин
**1,527**

Амьсгалын тогтолцооны өвчин
**1,782**



**63 хавдрын тохиолдлоос 44 хувь нь эрт үе**

**Хортой хавдрын *21 тохиолдлыг* Орхон Аймагт салст хуулах мэс заслаар эмчлэн эрүүлжүүлсэн.**

*2024 оны 04 сарын 04-ны өдрийн байдлаар*

# Халдварт өвчин:






Салхин цэцэг өвчний дэгдэлт бүртгэгдсэн байна.

Сүрьеэ болон бэлгийн замаар дамжих халдвар тэрүүлэх байр эзэлж байна.



# Томуу, томуу төст өвчний хариу арга хэмжээ



**Томуугийн тусламж үйлчилгээ, хариу арга хэмжээ**

- **АНХАН ШАТЛАЛД**
  - Утлага эмчилгээ-254
  - Өдрийн эмчилгээ-48
  - Гэрийн эргэлт- 2277
  - Эрсдэлт бүлгийн хяналт-34018 хүн
  - Эм, эмнэлгийн хэрэгсэл-100%
  - Багаж тоног төхөөрөмжийн хангамж 95%
  - Уртасгасан цагийн зохицуулалт



- **ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР**
  - ✓ Салбар дундын мэдээ, мэдээлэл шуурхай солилцох
  - ✓ Томуугийн ажлын хэсэг
  - ✓ Томуугийн харуулдан тандалтын нэгж, ХӨСҮТ, эргэн мэдээлэл
  - ✓ Дэмжлэгт хяналт, зөвлөгөө
  - ✓ Томуугийн ЭМСурталчилгаа
  - ✓ Томуугийн ХАХ-ны зардал-155,3 сая

- **2-Р ШАТЛАЛД**
  - Хүүхдийн хүлээн авах, тасагт нэмэлтээр 87 эмч, сувилагч
  - 250 хүртэл орыг нэмж дэлгэх бэлэн байдлыг хангана-157 хүүхэд
  - Эм, эмнэлгийн хэрэгсэл хангалт - 100%
  - Багаж тоног төхөөрөмжийн хангалт-88,0%



**САЛБАР ДУНДЫН ЗОХИЦУУЛАЛТ**
- 5 хүртэл насны ТТӨ-тэй хүүхдийг асрах чөлөөг олгох
- Хүүхийн байгууллагад олон нийтийн үйл ажиллагааг хориглох
- Томуугийн үеийн эмийн үнийн судалгаа

# Халдварт өвчний тандалт, судалгаа:

- Дархлаажуулалтын хамралт 99,8% буюу өнгөрсөн оны мөн үеэс 1% нэмэгдсэн.
- **18** явуулын цэгт **22** өдөр **930** иргэнийг үзлэгт хамруулж, **43** хүнээс цэрний шинжилгээ авч, **7** шинэ тохиолдол, **4** далд халдварыг илрүүлж сүрьеэгийн эмчилгээнд хамруулсан.
- БЗДХ-ын кабинетаар 5382 хүн үйлчлүүлснээс **71.8%** нь урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан байна. БЗДХ-ын 148 тохиолдлын 156 хавьтал илрүүлж хавьтлын өвчлөл /8/ **100%** эмчлэн эрүүлжүүлсэн.
- Орхон аймаг 2022 онд 1-12 насны нийт хүүхдийнхээ **24,4%**, 2023 онд **19,8%**-ийг нь томуугийн эсрэг дархлаажуулалтад хамруулснаар дархлаажуулалтад хамрагдсан хүүхдийн ТТӨ өвчлөл өмнөх оны мөн үеэс **0.04%**-өөр өссөн байна. Дээрх үзүүлэлтээс харахад вакцины хамралт буурахад өвчлөл ихсэх хандлагатай байна.





# Орон нутгийн хөрөнгө оруулалт

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН УДИРДАХ АЖИЛТНЫ ЗӨВЛӨГӨӨН
2024 ОРХОН АЙМАГ



**Жирэмсэн болон хөхүүл эхчүүдийн аминдэмжүүлэлт**
**(ОНТ 10 сая)**

Зорилтот бүлгийн жирэмсэн болон хөхүүл эхчүүдийг 100% аминдэмжүүлэлт /ферровит/-д хамруулсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1,4 дахин нэмэгдсэн байна. Аминдэмжүүлэлтийн үр дүн 90% бөгөөд эхчүүд эх барихын хүндрэлгүй төрсөн байна.



**“Эрүүл мэндийн дэмжигч байгууллага”**
**(ОНТ-6,0 сая)**

Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/472 дугаар тушаал, Орхон аймгийн 2018 оны А/ дугаар захирамжийн дагуу эрүүл мэндийг дэмжих ажлуудыг санаачлан, нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлж 2023 онд 5 байгууллага шинээр, 4 байгууллага зэрэглэл ахиулсан.




**“Энэ жилдээ эрүүл жиндээ” төсөл**
**(ОНТ-4,0 сая)**

Энэ жилдээ эрүүл жиндээ аяны хүрээнд нийтийг хамарсан алхалтыг 9 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 1000 орчим иргэд алхсан байна. Мөн төрийн байгууллагуудийн дунд жин хасах тэмцээнийг сарын хугацаанд зохион байгуулж 10 байгууллагын 60 албан хаагч хамрагдсан.

# Орон нутгийн хөрөнгө оруулалт





**“Дусал цус амьдрал бэлэглэнэ” аян**
**(ОНТ 5,0 сая)**

471 донороос 1065 нэгж цус цусан бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн. Аяны хүрээнд 30 байгууллагын 174 хүн цусаа хандивласан байна.



**Зуны чийрэгжүүлэлтийн гэр сувилал**
**(ОНТ 30,0 сая)**

Хүүхэд бүрт тохирсон хоол эмчилгээ, нэмэлт аминдэмжүүлэлтэнд сульдаа, ураг илчлэгийн дутагдал, цус багадалт зэрэг суурь эмгэгтэй болон хөгжлийн бэрхшээлтэй 150 хүүхдийг хамруулан нар ус агаараар чийрэгжүүлэн эрүүлжүүлсэн.

# Шинээр хэрэгжүүлсэн төсөл






**"Зөвийг дадал болгоё" төсөл**
**(ОНТ 25,0 сая)**

ЕБС-ийн 4-5 дугаар ангийн 2100 сурагч, 500 иргэнийг шүд угаах сургалтад хамруулан, мэдлэг, дадал олгосон. Шүдний олимпиадыг зохион байгуулсан.




**"Эрүүл Эрдэнэт хүн" төсөл (ОНТ 90,0 сая)**

Нийт 31074 иргэнд хүрч ажилласан ба үүнээс эрүүл мэндийн даатгалгүй 955 иргэн хамрагдсан байна. Тус үзлэгээр тэмбүү-4, элэгний В,С вирусын халдвар-21, хавдрын 7 тохиолдол /элэгний хавдар 3 /2,4-р шатанд/, 1 түрүү булчирхай /3-р шатанд/, 1 ходоод /1-р шатанд/, бүдүүн шулуун гэдэсний хавдар 2/ батлагдаж, лавлагаа шатлалд илгээн онош баталгаажсан байна.




**"6 настай хүүхдийн зүрхний эмгэг илрүүлэх" төсөл**

2298 хүүхдийг зүрхний цахилгаан бичлэгт хамруулан өөрчлөлтэй гарсан 200 хүүхдийг нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамруулснаас 73 хүүхдэд зүрхний эмгэг илэрч 3 хүүхэд хагалгаанд орж эмчлэгдсэн.

# ЭМЯ дэмжих сангийн төсөл

## “Ний нуугүй ярилцъя” төсөл
(ЭМДэмжих сан 13,5 сая)

- 1000 хүнд бэлгийн эрүүл мэндийн боловсрол олгосон.
- Мэдлэгийн түвшин 22-34% дээшилсэн.










## “Сэтгэцийн эрүүл мэндийн боловсролыг хүн бүрд” аян
(ЭМДэмжих сан 16 сая)

- 3000 хүнд сэтгэл зүйн тусламж үйлчилгээг хүргэн ажилласан.









# Гепатитын В, Д вирусийн халдвартай иргэдэд үзүүлэх тусламж, үйлчилгээг сайжруулах



**Эрүүл мэндийн газрын даргын 2023 оны 12-р сарын 20-ны өдрийн А/115 тоот тушаал**

**Үйл ажиллагааны хүрээнд:**

1. БОЭТ-ийн Лабораторийн тасгийн 2 эмчийг чадахжуулахаар ХӨСҮТ-ийн Гепатит энтеровирусийн лаборатори ажлын байрны сургалтад хамруулсан.
2. “Халдварын хяналт сэргийлэлтийн ажилтан бэлтгэх” 3 төрлийн сургалтад ЭМБ-ын болон Үсчин гоо сайхны холбооны нийт 200 эмч, ажилчид хамрагдсан.





3. В вирусийн эсрэг вакцины дархлаа тогтоцын шинжилгээнд эрүүл мэндийн 200 эмч, ажилтан хамрагдсан.

4. БОЭТ-д В вирус тоолох, Д вирус тоолох шинжилгээ нэтрүүлэхээр ажиллаж байна.

# Нийгмийн эрүүл мэндийн төвийн 2024 оны үйл ажиллагааны чиглэл

## 6 зорилтын хүрээнд 29 ажил төлөвлөсөн

**Зорилт 1**

Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж чанарыг сайжруулах

**Зорилт 2**

Хүн амыг нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд хамрагдалтыг нэмэгдүүлэх

**Зорилт 3**

Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг өргөжүүлж, нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр ажиллах хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлэх

**Зорилт 4**

Хүн амын дунд эрүүл мэндийн эрсдэлт хүчин зүйлийн тандалт, судалгааг хийж, дүгнэлт, зөвлөмж гаргах

**Зорилт 5**

Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, олон нийтийн оролцоо, салбар дундын хамтын ажиллагааг сайжруулах замаар эрүүл мэндийг дэмжих орчин бий болгох

**Зорилт 6**

Халдварт өвчний тандалт, сэргийлэлт, дархлаажуулалт, бэлэн байдал, хариу арга хэмжээ, салбар хоорондын хамтын ажиллагааний чадавхыг бэхжүүлж

# Тулгамдаж буй асуудал



- Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хэрэгжүүлэгч анхан шатанд хүний нөөцийн тогтвортой байдал хамгийн бага буюу 1-5 жил байна.
- Санхүүжилт хөрөнгө оруулалтын 22.8%, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хийгдэж байна.
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний 70% амбулаторийн болон стационарын тусламж, үйлчилгээ эзэлж байна.
- Иргэдийн эрүүл мэндийн боловсрол хангалтгүй хэвээр байна.

# Цаашид тавих санал:



- Орон нутагт нийгмийн эрүүл мэндийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах чиг үүрэг бүхий мэргэжилтнүүдийг арга зүйгээр хангах
- Улсын хэмжээнд нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хууль сурталчлах, хэрэгжилтийг хангах арга хэмжээ зохион байгуулах
- Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн үнэлгээний шалгуурт нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг гол үзүүлэлт болгох
- Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний санхүүжилтийг нэмэгдүүлэх

# Анхаарал хандуулсанд баярлалаа!